



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/610

Булган сум

**Жүгдэрдэмидийн Гүррагчаагийн
сансарт ниссэний 45 жилийн ойд хүндэтгэл
үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гурванбулаг сумын уугуул Монгол Улсын сансрын нисгэгч Жүгдэрдэмидийн Гүррагчаагийн сансарт ниссэний 45 жилийн ойг тохиолдуулан хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 3,500,000 (гурван сая таван зуун мянга) төгрөгийн зардлыг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д. ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 26-ны/ний өдрийн
А/210 дугаар захирамжийн хавсралт



Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
1	Хүндэтгэл үзүүлэх	1	2,000,000	2,000,000
2	Айраг	60л	10,000	600,000
3	Хүлээн авалт	-	900,000	900,000
Нийт			3,500,000	

--o00o--